



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- |      |   |  |      |
|------|---|--|------|
| 248. | Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомслоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай |  | 1139 |
| 249. | Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай                        |  | 1148 |

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- |      |  |           |      |
|------|--|-----------|------|
| 250. | Тогтоолд нэмэлт оруулах тухай          | Дугаар 12 | 1150 |
| 251. | Хянан шалгах түр хороо байгуулах тухай | Дугаар 14 | 1151 |

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- |      |  |           |      |
|------|--|-----------|------|
| 252. | Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай | Дугаар 12 | 1153 |
| 253. | Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай | Дугаар 13 | 1153 |
| 254. | Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай | Дугаар 14 | 1154 |

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- |      |                             |            |      |
|------|-----------------------------|------------|------|
| 255. | Дүрэм шинэчлэн батлах тухай | Дугаар 213 | 1154 |
|------|-----------------------------|------------|------|



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 04 дүгээр  
сарын 15-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЗАРИМ БАРАА, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН ӨСӨЛТ, ХОМСТЛООС СЭРГИЙЛЭХ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТУХАЙ**

#### **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

##### **1 дүгээр зүйл.Хуулийн зорилго**

1.1.Энэ хуулийн зорилго нь олон улсын хямралт байдлын улмаас үүсэж байгаа гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах асуудлыг онцгой журмаар шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

##### **2 дугаар зүйл.Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах хууль тогтоомж**

2.1.Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

##### **3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ**

3.1.Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, шаардлагатай нөөц бүрдүүлэх үйл ажиллагааг энэ хуулиар зохицуулах бөгөөд эдгээртэй холбогдсон бусад харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

3.2.Энэ хуулийн 3.1-д заасан гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүнд дараах бараа, бүтээгдэхүүн хамаарна:

- 3.2.1.газрын тосны бүтээгдэхүүн;
- 3.2.2.гурил;
- 3.2.3.мах.

<sup>1</sup>Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ  
ТӨРИЙН БАЙГУУЛЛАГААС АВЧ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**

**4 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлаас авч хэрэгжүүлэх  
арга хэмжээ**

4.1. Монгол Улсын Их Хурал энэ хуульд заасан бараа, бүтээгдэхүүнийг үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулахтай холбогдсон хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг дараалал харгалзахгүй яаралтай хэлэлцэн шийдвэрлэнэ.

**5 дугаар зүйл. Монголбанкнаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ**

5.1. Монголбанк энэ хуульд заасан гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, шаардлагатай нөөц бүрдүүлэх талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

5.1.1. мах, гурилын нөөц бүрдүүлэх, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах зорилгоор мах бэлтгэн нийлүүлэгч, гурил үйлдвэрлэгч аж ахуйн нэгжид эргэлтийн хөрөнгөд шаардагдах хөнгөлөлттэй санхүүжилтийг банкны эх үүсвэрээр олгох;

5.1.2. газрын тосны бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх зорилгоор газрын тосны бүтээгдэхүүн импортлогчид эргэлтийн хөрөнгийн болон урьдчилгаа төлбөр төлөхөд шаардагдах санхүүжилтийг репо арилжааны нөхцөлөөр банканд олгох;

5.1.3. санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглан энэ хуулийн 3.2.1-д заасан бараа, бүтээгдэхүүний импортод шаардлагатай гадаад валютыг ханшийн эрсдэлийг бууруулж импортлогчдод нийлүүлэх бөгөөд банк энэ эх үүсвэрээр ашиг олох зорилгоор арилжаа хийхийг хориглох;

5.1.4. гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор алт олборлогч аж ахуйн нэгжид эргэлтийн хөрөнгийн болон урьдчилгаа төлбөрийн санхүүжилтийг олгох;

5.1.5. шаардлагатай тохиолдолд банкнаас зээл олгоход тавигдах зохистой харьцааны болон бусад шалгуур үзүүлэлт, зээлийн шаардлага, нөхцөлийг тусгайлан тогтоох;

5.1.6. Лондонгийн металлын биржийн үнэ дээр таван хувийн нэмэгдэлтэйгээр гадаад, дотоодын зах зээлээс алт худалдан авч гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх.

## **6 дугаар зүйл.Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээ**

6.1.Засгийн газар гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, шаардлагатай нөөц бүрдүүлэх талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

6.1.1.энэ хуулийн 3.2-т заасан бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хангамж, нийлүүлэлтийн хомстол үүсэхгүй байх арга хэмжээ авах, цогц төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх;

6.1.2.энэ хуулийн 5.1.1-д заасан хөнгөлөлттэй зээл олгоход шаардагдах хүүгийн татаасыг тухайн жилийн төсөвт тусган шийдвэрлэх;

6.1.3.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд<sup>2</sup> заасан хязгаарын хүрээнд энэ хуульд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын үнэт цаас, баталгаа гаргах;

6.1.4.энэ хуульд заасан зохицуулалтад хамрагдсан бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, импортлох, худалдаалах аж ахуйн нэгжтэй нийлүүлэлт, үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор талуудын эрх үүрэг, хүлээх хариуцлагыг тусгасан гэрээ байгуулан, биелэлтийг хангуулан ажиллах.

## **7 дугаар зүйл.Газрын тосны бүтээгдэхүүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ**

7.1.Газрын тосны бүтээгдэхүүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, шаардлагатай нөөц бүрдүүлэх талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

7.1.1.газрын тосны бүтээгдэхүүний үнийн өсөлт, хангамж, нийлүүлэлтийн хомстол үүсэхгүй байх ажлыг зохион байгуулах;

7.1.2.газрын тосны бүтээгдэхүүн импортлох тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжтэй нийлүүлэлт, үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор оролцогч талуудын эрх үүрэг, хүлээх хариуцлагыг тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбогдсон хариуцлагын гэрээ байгуулан, биелэлтийг ханган ажиллах.

<sup>2</sup>Төсвийн тогтвортой байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2010 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

## **8 дугаар зүйл. Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ**

8.1. Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, шаардлагатай нөөц бүрдүүлэх талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

8.1.1. Хүнсний тухай хуулийн<sup>3</sup> 6.7-д заасны дагуу энэ хуулийн 3.2.2, 3.2.3-т заасан хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт, хангамж, нийлүүлэлтэд хомстол үүсэхээс сэргийлж экспортлох хүнсний нэр төрөл, тоо хэмжээг тухай бүр тогтоож мөрдүүлэх;

8.1.2. Энэ хуулийн 3.2.2, 3.2.3-т заасан хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, импортлох, худалдаалах аж ахуйн нэгжтэй нийлүүлэлт, үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор оролцогч талуудын эрх үүрэг, хүлээх хариуцлагыг тусгасан гэрээ байгуулан, биелэлтийг ханган ажиллах.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

### **9 дүгээр зүйл. Бусад зүйл**

9.1. Энэ хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс өмнөх хугацаанд Ашигт малтмалын тухай хуулийн<sup>4</sup> 35.6-д заасныг зөрчсөн этгээдийг энэ хууль үйлчлэх хугацаанд аливаа хариуцлагаас чөлөөлнө.

### **10 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хугацаа**

10.1. Энэ хууль 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд үйлчилнэ.

### **11 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

11.1. Энэ хуулийг 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

<sup>3</sup>Хүнсний тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2013 оны 02 дугаарт нийтлэгдсэн.

<sup>4</sup>Ашигт малтмалын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2006 оны 30 дугаарт нийтлэгдсэн.















## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 04 дүгээр  
сарын 15-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.4, 15.5 дахь хэсэг нэмсүгэй:

“15.4. Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн 20 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй тэнцэх хэмжээний биет үнэт металл, бэлэн гадаад валютыг Монгол Улсын хилээр гаргахыг хориглоно.

15.5. Энэ хуулийн 15.4-т заасан үнийн дүн хүртэлх хэмжээний биет үнэт металл, бэлэн гадаад валютыг гаальд мэдүүлснээр Монгол Улсын хилээр гаргаж болно.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд дагаж мөрдөнө.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**





## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 дүгээр  
сарын 15-ны өдөр

Дугаар 12

Улаанбаатар  
хот

### Тогтоолд нэмэлт оруулах тухай

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын 4 дэх заалтын “26, ” гэсний дараа “27, ” гэж нэмсүгэй.

2.Энэ тогтоолыг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд дагаж мөрдсүгэй.

3.Энэ тогтоолыг 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

Үсэнтэй, хэмжээгээр, үсэнтэй, үсэнтэй, үсэнтэй

᠒᠐᠒᠒ оны ᠐᠔ сарын 15 - өдөр  
Монгол Улсын Их Хурлын Тогтоол  
№ 12

Монгол Улсын Их Хурлын Тогтоолыг  
Монгол Улсын Их Хурлын Тогтоолыг

Тогтоолын 4 дүгээр хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:  
1. “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын 4 дэх заалтын “26, ” гэсний дараа “27, ” гэж нэмсүгэй.

2. Энэ тогтоолыг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд дагаж мөрдсүгэй.

3. Энэ тогтоолыг 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Улаанбаатар хот



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 04 дүгээр  
сарын 15-ны өдөр

Дугаар 14

Улаанбаатар  
хот

### Хянан шалгах түр хороо байгуулах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.2, 34.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Хөгжлийн банкны асуудлаар Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

#### Олонхыг төлөөлөн:

Д.Батлут	Улсын Их Хурлын гишүүн
Э.Батшугар	Улсын Их Хурлын гишүүн
Б.Бат-Эрдэнэ	Улсын Их Хурлын гишүүн
Ж.Бат-Эрдэнэ	Улсын Их Хурлын гишүүн
Л.Мөнхбаатар	Улсын Их Хурлын гишүүн
Ц.Мөнхцэцэг	Улсын Их Хурлын гишүүн
Ж.Сүхбаатар	Улсын Их Хурлын гишүүн
Б.Энхбаяр	Улсын Их Хурлын гишүүн

#### Цөөнхийг төлөөлөн:

Ж.Батсуурь	Улсын Их Хурлын гишүүн
Н.Ганибал	Улсын Их Хурлын гишүүн
Т.Доржханд	Улсын Их Хурлын гишүүн

2.Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны шалгалтын сэдэв, хүрээ хязгаарыг Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явц, байдлыг шалгахгаар тогтоосугай.

3.Энэ тогтоолыг 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**







## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 02 дугаар  
сарын 08-ны өдөр

Дугаар 12

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Израил Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Равдангийн Болдыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Израил Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гомбосүрэнгийн Мөнхбаярыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 02 дугаар  
сарын 08-ны өдөр

Дугаар 13

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Мальта Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Цэрэндоржийн Жамбалдоржийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Мальта Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Цэрэндоржийн Нарантунгалагийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 02 дугаар  
сарын 08-ны өдөр

Дугаар 14

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Серби Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Зэнээмъядарийн Батбаярыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Серби Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Сайннямбуугийн Баатаржавыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 7 дугаар  
сарын 20-ны өдөр

Дугаар 213

Улаанбаатар  
хот

### Дүрэм шинэчлэн батлах тухай

Барилгын тухай хуулийн 32.1.10-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм”-ийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Шинэчлэн батлагдсан дүрмийн хэрэгжилтийг улсын хэмжээнд хангуулж ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатарт, аймаг, нийслэлийн хэмжээнд хангуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.



3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Дүрэм батлах тухай” Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 68 дугаар тогтоол, “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2017 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 171 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Л.ОЮУН-ЭРДЭНЭ**

**БАРИЛГА, ХОТ  
БАЙГУУЛАЛТЫН САЙД**

**Б.МӨНХБААТАР**

Засгийн газрын 2021 оны 213 дугаар  
тогтоолын хавсралт

**БАРИЛГЫН АЖЛЫГ ЭХЛҮҮЛЭХ, ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ДҮРЭМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэ дүрмийн зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт баригдах барилга, байгууламжид Барилгын тухай хуульд заасны дагуу барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл (цаашид “барилгын ажлын зөвшөөрөл” гэх) олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Барилгын ажлын зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулахад Барилгын тухай хуулийн 26 дугаар зүйл болон энэ дүрмийг баримтална.

1.3.Энэ дүрмийн зохицуулалт Барилгын тухай хуулийн 10.1.1-д заасан барилга байгууламжид хамаарахгүй бөгөөд барилгын ажлын захиалагч (цаашид “захиалагч” гэх) шаардлагатай гэж үзсэн тохиолдолд энэ дүрмийг жишиг болгон мөрдөж болно.

Хоёр. Барилгын ажлын зөвшөөрлийн хүсэлт гаргах

2.1.Захиалагч барилгын ажлын зөвшөөрлийн хүсэлтийг барилга байгууламжийн төвөгшлийн ангиллаас хамааран дараахь байгууллага, албан тушаалтанд гаргана:

2.1.1.Барилгын тухай хуулийн 32.1.5-д заасан барилга байгууламжийн барилгын ажлын зөвшөөрлийн хүсэлтийг холбогдох төрийн



захиргааны төв байгууллагаар дамжуулан барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад;

2.1.2.энэ дүрмийн 2.1.1-д зааснаас бусад барилга байгууламжийн барилгын ажлын зөвшөөрлийн хүсэлтийг аймаг, нийслэлийн Засаг даргад.

2.2.Захиалагч нь барилгын ажлын зөвшөөрлийн хүсэлтэд Барилгын тухай хуулийн 28.2, 28.3, 28.4-т заасан баримт бичгийг хавсаргасан байна.

#### Гурав. Барилгын ажлын зөвшөөрлийн хүсэлтийг шийдвэрлэх

3.1. Барилгын ажлын зөвшөөрлийн хүсэлтийг дараахь байгууллага, албан тушаалтан шийдвэрлэнэ:

3.1.1.Барилгын тухай хуулийн 32.1.5-д заасан барилга байгууламжийн барилгын ажлын зөвшөөрлийн хүсэлтийг Засгийн газар;

3.1.2.энэ дүрмийн 3.1.1-д зааснаас бусад барилга байгууламжийн барилгын ажлын зөвшөөрлийн хүсэлтийг аймаг, нийслэлийн Засаг дарга.

3.2.Захиргааны ерөнхий хуулийн 10.1.2-т заасны дагуу аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан хүсэлтийг үндэслэн Барилгын тухай хуулийн 10.1.5-д заасан барилга байгууламжийн барилгын ажлын зөвшөөрлийн хүсэлтийг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэж болно.

3.3.Барилгын тухай хуулийн 32.1.5-д заасан барилга байгууламжийн барилгын ажлын зөвшөөрлийн хүсэлтийг дараахь журмаар шийдвэрлэнэ:

3.3.1.хүсэлтийг хүлээн авсан төрийн захиргааны төв байгууллага нь энэ дүрмийн 2.2-т заасан баримт бичгийн бүрдлийг хянан шалгаж, зөвшөөрөл олгох үндэслэлтэй эсэх талаар дүгнэлт гаргах бөгөөд хүсэлт болон дүгнэлтийг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ;

3.3.2.барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Барилгын тухай хууль болон энэ дүрэмд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянаж, Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлүүлнэ.

3.4.Зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдөрт багтаан шийдвэрлэнэ.

3.5.Эрх бүхий байгууллага барилгын ажлын зөвшөөрлийн хүсэлтийг хянах явцад шаардлагатай бол холбогдох байгууллагаас тодруулга авч болно.

3.6.Энэ дүрмийн 3.5-д заасны дагуу тодруулга авсан тохиолдолд барилгын ажлын зөвшөөрлийн хүсэлтийг хянан шийдвэрлэх хугацааг шинээр тоолно.

3.7.Цогцолбор барилгын ажлын зөвшөөрөл олгохдоо цогцолборын эх загвар зургийн магадлалын дүгнэлтэд үндэслэн шийдвэрлэнэ.

3.8.Барилгын ажлын зөвшөөрлийг барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөлд заасан графикт хугацаа буюу барилгын ажил гүйцэтгэх хугацаагаар олгоно.

3.9.Барилгын тухай хуулийн 10.1.5, 32.1.5-д заасан барилга байгууламжийн хувьд шаардлагатай тохиолдолд инженерийн бэлтгэл ажилд барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгож болно.

3.10.Барилга байгууламжийн буулгалтын ажлын зөвшөөрлийг Барилгын тухай хуулийн 16.3-т заасан зураг төсөл, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны арга хэмжээний төлөвлөгөө, буулгах ажлын технологид үндэслэн шийдвэрлэнэ.

#### Дөрөв. Барилга байгууламжийн зөвшөөрөл олгох

4.1.Барилгын ажлын зөвшөөрлийг энэ дүрмийн 1 дүгээр хавсралтад заасан гэрчилгээгээр баталгаажуулан олгоно.

4.2.Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээг 2 хувь үйлдэж, захиалагчид 1 хувийг олгож, үлдсэн хувийг архивт хадгална.

4.3.Барилгын ажлын зөвшөөрлийг цахим хэлбэрээр олгож болох бөгөөд цахим гэрчилгээг зохих журмын дагуу архивт хадгална.

4.4.Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээнд энэ дүрмийн 2, 3 дугаар хавсралтад заасны дагуу хугацаа сунгалт болон нэмэлт, өөрчлөлтийг бүртгэнэ.



4.5.Захиалагч барилгын ажлын явцад дараахь өөрчлөлт гарсан тохиолдолд Барилгын тухай хууль болон энэ дүрэмд заасны дагуу зохих арга хэмжээг авч, зөвшөөрөл олгосон байгууллагад тухай бүрд нь мэдэгдэнэ:

4.5.1.барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээнд заасан мэдээлэлд өөрчлөлт орсон;

4.5.2.гүйцэтгэгч, захиалагч болон зохиогчийн хяналт хэрэгжүүлэх байгууллага өөрчлөгдсөн;

4.5.3.гүйцэтгэгчийн тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан;

4.5.4.барилга байгууламжийн үндсэн хийц бүтээцэд өөрчлөлт оруулж, зураг төсөл өөрчлөгдсөн;

4.5.5.дуусаагүй барилга байгууламжийг хамгаалалтын горимд оруулах болон уг хугацаа дуусгавар болсон.

4.6.Зөвшөөрөл олгох байгууллага барилгын ажлын явцад өөрчлөлт орсон тохиолдол бүрд энэ дүрмийн 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу өөрчлөлтийг бүртгэж, гэрчилгээнд хавсаргана.

4.7.Барилгын тухай хуулийн 30.2-т заасны дагуу барилгын ажлын зөвшөөрлийн хугацааг сунгасан тохиолдолд энэ дүрмийн 3 дугаар хавсралтад заасан маягтын дагуу бүртгэж, гэрчилгээнд хавсаргана.

4.8.Барилгын тухай хуулийн 30.2-т заасан хугацаанд зөвшөөрлийг сунгуулах тухай хүсэлт ирүүлээгүй бол Барилгын ажлын зөвшөөрлийн хугацааг сунгахгүй бөгөөд зөвшөөрлийн хугацаа дуусмагц гэрчилгээг хүчингүйд тооцно.

#### Тав. Барилгын ажлын зөвшөөрөл олгохоос татгалзах

5.1.Зөвшөөрөл олгох байгууллага дараахь үндэслэлээр барилгын ажлын зөвшөөрөл олгохоос татгалзна:

5.1.1.баримт бичгийн бүрдэл дутуу, эсхүл хуурамчаар үйлдэж бүрдүүлсэн;

5.1.2.баримт бичиг холбогдох хууль тогтоомжид заасан шаардлага (гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч болон өргөх байгууламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагын тусгай зөвшөөрлийн болон техникийн



нөхцөлийн хугацаа дуусгавар болсон, байршил, газар олголт, төлөвлөлтийн болон норматив баримт бичгийн шаардлагыг зөрчсөн)-д нийцээгүй.

5.2.Барилгын ажлын зөвшөөрөл олгохоос татгалзсан шийдвэрийг бичгээр гаргаж, хүсэлт гаргагчид хүргүүлнэ.

### Зургаа. Бүртгэл, мэдээлэл

6.1.Захиалагч барилгын ажлын зөвшөөрлийн талаарх мэдээллийг барилгын ажлын талбайн мэдээллийн самбарт байрлуулна.

6.2.Барилгын ажил гүйцэтгэгч нь өөрийн товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж байгаа ажил болон ажил эхлэх, дуусах хугацааны талаарх холбогдох мэдээллийг агуулсан самбарыг нийтэд үзэгдэхүйц газарт тухайн ажлыг гүйцэтгэх хугацааны туршид байрлуулна.

6.3.Зөвшөөрөл олгосон байгууллага нь тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд барилгын ажлын зөвшөөрөл олгосон, цуцалсан, хугацаа сунгасан барилгын ажлын зөвшөөрлийн бүртгэлийг хөтлөх чиглэлээр дараахь үүрэгтэй:

6.3.1.зөвшөөрөл олгосон, өөрчилсөн, цуцалсан тохиолдол бүрийг бүртгэж, барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хот байгуулалтын кадастрын цахим мэдээллийн санд тухай бүр байршуулах;

6.3.2.зөвшөөрөл олгосон талаарх мэдээллийг ажлын 5 өдөрт багтаан барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагад тус тус хүргүүлэх;

6.3.3.зөвшөөрөлтэй холбоотой тайланг хагас жил тутам нэгтгэн гаргаж барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

### Долоо. Бусад

7.1.Барилгын ажлын зөвшөөрөл зохих ёсоор олгогдоогүй барилга байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэхийг хориглоно.

7.2.Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрт зааснаас бусад тохиолдолд Барилгын ажлын зөвшөөрөл олгогдоогүй барилга байгууламжид зөвшөөрлийг нөхөж олгохыг хориглоно.

7.3.Энэ дүрмийг зөрчсөн албан тушаалтан, хувь хүн, хуулийн этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.





Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх  
зөвшөөрөл олгох дүрмийн 1 дүгээр хавсралт

## БАРИЛГЫН АЖЛЫН ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

(Загвар)

/Аймаг, хотын нэр/

/Зөвшөөрөл олгосон огноо/

/Зөвшөөрлийн дугаар/

1.Барилга байгууламжийн байршлын талаарх мэдээлэл:

..... аймаг /нийслэл/, ..... сум /дүүрэг/,  
..... баг /хороо/, ..... гудамж /хороолол/;

2.Газрын эрхийн бүртгэлийн мэдээлэл:

Иргэний хувьд: ..... харьяалал /аль улсын/, ..... овог,  
.....эцэг /эх/-ийн нэр, ..... нэр.

Хуулийн этгээдийн хувьд: ..... оноосон нэр, .....  
улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, .....  
газрын эрхийн хэлбэр (өмчлөх, эзэмших, ашиглах), ..... газрын  
зориулалт, ..... талбайн хэмжээ, ..... газар  
эзэмших, ашиглах хугацаа, ..... кадастрын код;

3.Барилгын ажлын зөвшөөрлийн хүчинтэй хугацаа:

..... барилгын ажил гүйцэтгэх графикт хугацаа;

4.Барилга байгууламжийн талаарх мэдээлэл:

..... зориулалт, ..... хүчин чадал, ..... үндсэн  
хийц, ..... хэмжээ, ..... давхрын тоо, ..... хэсэг /блок/, ..... зураг  
төслийн шифр дугаар;

5.Барилга байгууламжийн ангилал: .....  
төвөгшилтэй барилга байгууламж;

6.Барилгын ажлын захиалагчийн талаарх мэдээлэл:

Иргэний хувьд: ..... харьяалал /аль улсын/, .....  
овог, ..... эцэг /эх/-ийн нэр, ..... нэр  
хаяг: ..... аймаг /нийслэл/, ..... сум /дүүрэг/



..... баг /хороо/, ..... гудамж /хороолол/ ..... байр /хашаа,  
хаалга/-ны дугаар, ..... холбоо барих утас, ..... цахим хаяг;

Хуулийн этгээдийн хувьд: ..... оноосон нэр, ..... улсын  
бүртгэлийн гэрчилгээний дугаар,  
хаяг: ..... аймаг /нийслэл/, ..... сум /дүүрэг/ .....  
баг /хороо/, ..... гудамж /хороолол/ ..... байр /хашаа,  
хаалга/-ны дугаар, ..... холбоо барих утас, .....  
цахим хаяг;

7.Барилгын зураг төсөл зохиогчийн талаарх мэдээлэл:

..... хуулийн этгээдийн оноосон нэр, ..... улсын  
бүртгэлийн гэрчилгээний дугаар, ..... зураг төсөл  
боловсруулах тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар,  
хаяг: ..... аймаг /нийслэл/, ..... сум /дүүрэг/ .....  
баг /хороо/, ..... гудамж /хороолол/, ..... байр /хашаа,  
хаалга/-ны дугаар, ..... холбоо барих утас, .....  
цахим хаяг;

8.Барилгын ажлын гүйцэтгэгчийн талаарх мэдээлэл:

..... хуулийн этгээдийн оноосон нэр, ..... улсын  
бүртгэлийн гэрчилгээний дугаар, ..... барилгын ажил  
гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар,  
хаяг: ..... аймаг /нийслэл/, ..... сум /дүүрэг/ .....  
баг /хороо/, ..... гудамж /хороолол/ ..... байр /хашаа,  
хаалга/-ны дугаар, ..... холбоо барих утас, ..... цахим хаяг;

9.Онцгойлон заах нөхцөл:

10.Барилгын ажлын зөвшөөрөл олгосон албан тушаалтны  
мэдээлэл:

..... байгууллагын нэр, ..... албан тушаал, .....  
овог нэр, ..... / гарын үсэг, (тамга, тэмдэг)

Тайлбар:Цахим хэлбэрээр Барилгын ажлын зөвшөөрлийн  
гэрчилгээг үзэх боломжийг бүрдүүлэх боломжтой байдлаар өгөгдөл  
хадгалах QR код нэмж болно.



Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх  
зөвшөөрөл олгох дүрмийн 2 дугаар хавсралт

БАРИЛГЫН АЖЛЫН ЗӨВШӨӨРЛИЙН НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

№	Өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Он, сар, өдөр	Гарын үсэг

Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх  
зөвшөөрөл олгох дүрмийн 3 дугаар хавсралт

БАРИЛГЫН АЖЛЫН ЗӨВШӨӨРЛИЙН  
ХУГАЦААНЫ СУНГАЛТ

/Барилгын ажлын зөвшөөрөл сунгасан огноо/

1. Барилгын ажлын зөвшөөрлийн хугацааг сунгах шалтгаан:

2. Барилгын ажлын төлөв байдал:.....үе шат  
..... гүйцэтгэсэн ажлын нэр, төрөл;

3. Барилгын ажил гүйцэтгэх хугацаа: .....

4. Барилгын ажлын зөвшөөрлийн хугацааг сунгасан ажилтны  
мэдээлэл: ..... байгууллагын нэр, .....албан тушаал,  
.....овог нэр, / ..... / гарын үсэг, (тамга, тэмдэг)

---o0o---



**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 1.75

**Индекс: 200003**